

Мод бэлтгэл

Ойгоос мод бэлтгэх

“Мод бэлтгэл” юуг хэлэх вэ? Энэ нь нэг ёсондоо ойчид ургацаа хурааж байгаа гэсэн үг юм. Бидэнд үр тариа, жимс жимсгэнэ хэчнээн хэрэгтэй байдаг шиг мод ч бас чухал хэрэгцээтэй.

Юу тарина түүнийгээ хураана гэдэг болохоор мод бэлтгэлийг зөв зохистой хийх нь маш чухал. Ойгоос мод бэлтгэх нь ойг гэмтээж хөнөөнө гэсэн үг биш харин ч ойд арчилгаа цэвэрлэгээ хийж ойн нөхөн сэргэлтэд эерэгээр нөлөөлдөг. Мод бэлтгэх хэд хэдэн аргачлал байдаг. Модны нас болсноос нь гадна мод бэлтгэх шалтгаанаар нь ангилдаг.

Мод бэлтгэхдээ

- ▶ Болц нь гүйцэхээс өмнөх мод бэлтгэл (арчилгааны) зорилго нь тогтвортой, эрүүл, чанартай ойн мод ургуулах. Үүнд тайралт, сийрэгжүүлэлт багтана.
- ▶ Болцыг нь гүйцээх мод бэлтгэл (нөхөн сэргээх) хийснээр 80 жилээс дээш настай модыг сэргээх
- ▶ Цэвэрлэгээ хийх – хүчтэй салхи шуурга, их цас, хөнөөлт шавьж мөөгөнцөрт идүүлж амьдрах чадваргүй болсон модыг ойгоос гаргах.

Мод бэлтгэх операц

Ой бас операцад ордог гэж үү? Үгүй ээ! Мод бэлтгэх ажлын явцыг операц гэж нэрлэдэг.

Мод бэлтгэлийн ажил шат дараалсан операцаар явагддаг:

- ▶ Огтлох – цахилгаан хөрөө эсхүл олон үйлдэлтэй машинаар огтлоно
- ▶ Мөчирлөх – унагасан модыг мөчирлөж ишээр нь түүхий эд бэлтгэх
- ▶ Хэрчих – ишээ хэрэгцээгээр хөрөөдөх
- ▶ Сортиментлэх – модыг чанар, өгөгдлийнх нь дагуу сортиментлэнэ
- ▶ Холтослох, хөрөөдөх, түлш бэлтгэх г.м.

Мод бэлтгэх аргачлал

Шоргоолж нь өөрийнхөө биеийн жингээс 20 дахин их ачаа даадаг! Модны иш ийм хэмжээний ачааг арай л дийлэхгүй!

Эцсийн дамжлагад хүргэх тээвэрлэлтийн хэлбэрүүд:

- ▶ Сортиментлох арга – унагасан модоо мөчирлөх, богиносгож хэрчих эсхүл сортиментлоно. Жижиг оврын техникийн тусламжтайгаар цагаалдаг тул ойн хүрээлэн буй орчинд хамгийн ээлтэй арга юм.
- ▶ Уртааши ишээр нь – мөчирлөсөн модоо уртааши ишээр нь ачна. Модыг ингэж ачих нь ажил багатай ч хүрээлэн буй орчинд ээлгүй.
- ▶ Цагаалаагүй – унагасан модоо мөчиртэй нь ачиж эцсийн дамжлагад хүргэнэ. Модны титэм мөргөлтийг сааруулдаг хэдий ч хүрээлэн буй орчны биомасс хорогддог.

Мод зөөх – бэлтгэсэн модыг агуулах эсхүл хэрэглэгчид хүргэж өгнө. Трактор, ган татлагат төхөөрөмж, ердийн хөсөг болон бусад аргаар зөөх бөгөөд эдгээрийг хослуулан ашиглаж болно.



Мод яаж бэлтгэдгийг та мэдэх үү? Одоо энэ тухай ярьж өгье!



Модыг ойгоос гаргах

Гидравлик гар суурилуулсан зориулалтын ачааны машинаар зөөнө.

Гидравлик гартайсан бол мөн ч их ажил амжуулахсан! Байхгүй болохоор техникийн тусалцаатай хийхээс өөр замгүй!

Ажил явуулах агуулах болон хөрөө раам

Агуулахад ихэвчлэн хоёр төрлийн ажил явуулдаг: тээвэрлэж ирсэн модыг буулгах, модыг төрөл зүйл болон цагаалсан ажилбараар нь сортиментлэнэ.

